

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

П.Лхамсүрэн*, Б.Уянга*

Монгол улсын гадаад худалдаанд эзлэх хөрш орнуудын байр суурь ихээхэн өндөр. Энэ нь тээвэрлэлтийн зардал, уламжлалт харилцаа холбоо, дотоодын хэрэглээний хязгаарлагдмал байдал буюу зах зээлийн багтаамж, дотоодын үйлдвэрлэлийн хөгжил ба бүтэц зэрэг олон зүйлээс шууд хамааралтай байдаг. Мөн далайд гарцгүй, гуравдагч орнуудтай хийх худалдаа, тээвэрлэлтийг заавал хоёр хөршийн нутгаар дамжуулан хийх шаардлагатай болдог зэрэг нь зарим талаараа тээвэрлэлтийн зардлыг өсгөж тус улсын экспортын өрсөлдөх чадварыг бууруулдаг боловч сүүлийн жилүүдэд манай улсын газарзүйн байршил үр ашигтай болон хувирч байна. Энэ нь эдийн засаг хурдацтай өсөж байгаа өмнөд хөрштэйгөө шууд хиллэдэг явдал юм. БНХАУ-ын эдийн засгийн тогтвортой өсөлт дэлхий нийтийн анхаарлыг татахын хамт энэ том зах зээлд өөрийн байр суурийг эзлэх сонирхол хөгжингүй улсууд, ҮДК-дад бий болоод байна. Сүүлийн жилүүдэд илрээд байгаа ашигт малтмалын баялаг ордууд, тэдгээрээс олборлох бүтээгдэхүүнийг экспортлох зах зээл бараг нэг дороо байгаа нь Монгол улсын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөртөө татах, уул уурхайд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бий болгох таатай боломж юм.

Эдийн засгийн өсөлтийг дагалдсан түүхий эдийн хэрэглээ, 1,3 тэрбум¹ хэрэглэгчийн зах зээлийн багтаамж нь энэ улсын үнэ цэнийг өсгөж байна. Тиймээс харилцан ашигтай хамтын ажиллагааны бүх хэлбэрийг хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь манай улсын нэн тэргүүний эрх ашиг юм. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн манай улсын экспортод нөлөөллийг тооцох зайлшгүй шаардлагатай. Нөгөө талаас авч үзвэл үйлдвэрлэлийн хөгжлийг дагалдсан түүхий эдийн хэрэглээгээ хямд, тасралтгүй хангах шаардлага байгаа. Энэ өгүүлэлд Монголын уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортын боломжийг нүүрсний салбараар төлөөлүүлэн судаллаа.

1. Монгол Улсын улс төр, эдийн засгийн өнөөгийн байдал

Монголчууд эрт дээр үеэс эхлэн нүүдлийн мал аж ахуй эрхэлж түүний ашиг шимийг хүртсээр ирсэн боловч өнөөгийн хот суурин газрын хүн амын хэрэгцээг энэ аргаар хангах боломжгүй гэдэг нь улам бүр тодорхой

* МУИС-ОУХС-ийн багш, докторант


* БНХАУ-ын ХААИС, Эдийн засаг-менежментийн сургууль, докторант

1. World factbook, China

болсоор байна. Ойролцоогоор нэг хүнд 15 толгой мал, 1 км.кв талбайд 2 хүн ноогдож байгаа боловч сүү, сүүн болон газар тариалангийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж чаддаггүй. Эндээс үзэхэд уламжлалт технологи дээр тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжгүй гэдэг нь улам бүр тодорхой болсоор байна. Технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд байгалийн баялагтаа тулгуурлан орлого олох, түүгээрээ оновчтой хөрөнгө оруулалт хийж хөгжих нь зүйтэй гэдэг дээр ихэнх судлаачид, улс төрийн зүтгэлтнүүд, эрх барьж буй парламентад суудалтай намуудын лидерүүд санал нэгдэж байна. Тухайлбал 2008 оны сонгуулийн үр дүнгээр олонхи болсон улс төрийн нам сөрөг хүчинтэйгээ хамтран эвслийн засгийн газар байгуулж “Оюу Толгой” бүлэг ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан.

Монгол орон өргөн уудам нутагт сийрэг оршдог цөөн хүн амтай, байгалийн арвин баялаг нөөцтэй улсын хувьд уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүрэн боломжтой. Доорхи графикт тус улсын нүүрсний нөөцийг харуулав.

Монгол орны нүүрсний геологийн нөөц (сая, тонн)



Эх үүсвэр: АМГТХЭГ, Уул уурхайн газар: Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа, дүгнэлт 2008 он

Судалгаагаар 175 орчим тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэж тооцож байгаагаас одоогоор батлагдсан нүүрсний нөөц 12 тэрбум тонн орчим. Энэ нөөц нь өндөр чанартай коксжих нүүрсний агууламжаар баялаг, том зах зээлтэй ойр оршдог зэргээрээ хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг. Тиймээс дэлхийн зах зээл дээрээс хөрөнгө босгох бололцоотой.

2. Монгол Улс ба БНХАУ-ын худалдаа:

1990-ээд оноос Монгол Улсын гадаад худалдааны бүтэц, агуулга үндсээрээ өөрчлөгдсөн. Улсын байгууллагын хөшүүн, худалдааг орлосон хувийн болон пүүс компаниудын худалдаа дотоодын хэрэгцээг хангахын хажуугаар хөдөө аж ахуйн түүхий эдийг экспортлох болсон. Тоо баримтаас харахад БНХАУ ба МУ-ын хоорондын худалдаа жилээс жилд өсөөр байна. Тухайлбал 1995 онд БНХАУ-руу 77,8 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолдог байсан бол 2012 онд энэ тоо 4059,7 сая ам.долларт хүрч 52 дахин өссөн. Харин нийт эргэлт дээрхи хугацаанд 122,3 сая ам.доллараас 5921,2² сая ам.доллар болж 48,4 дахин өсчээ. Нийт экспортод эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээ нэмэгдсээр байна. Энэ нь сүүлийн жилүүдэд манай гол экспортын бүтээгдэхүүн болох зэс, нүүрс, алтны үнэ өссөнтэй холбоотойгоос гадна хямд түүхий эдийг ойрын зайнаас хангах Хятад улсын сонирхолтой уялдаатай юм.

Хэдийгээр уул уурхайн экспортоос олох орлого нэмэгдэж байгаа ч дотоодын дэд бүтцийн тааруу хөгжлөөс шалтгаалан байгаль экологид сөргөөр нөлөөлдөг шороон замын авто тээвэр ашиглан нүүрс экспортолж байгаа нь **нэгдүгээрт**; тээвэрлэлтийн зардлыг өсгөж экспортын үр ашгийг бууруулж байна, **хоёрдугаарт**; говийн эмзэг хөрсийг сүйтгэж цөлжилтийг нэмэгдүүлж байна, **гуравдугаарт**; ерөөсөө уул уурхайг хөгжүүлэх нь өөрөө буруу юм гэсэн сэтгэгдэл, эсэргүүцлийг олон нийтэд төрүүлэх нэг шалтгаан болж байна.

Тиймээс уул уурхайн экспортоос олох орлого, хөрш орны эдийн засагт эзэлж байгаа байр суурийг сайтар тооцож, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгааг анхаарах шаардлагатай байна.

3. Нүүрсний экспортод нөлөөлөх БНХАУ-ын нөлөө

Нүүрсний экспортод үзүүлэх нөлөөллийг тооцохдоо эдийн засгийн судалгаанд түгээмэл ашиглагддаг Кобб-Дугласын функцийг ашиглав.

Нүүрсний экспорт нь Монгол улсын өөрийнх нь дотоодын нийт бүтээгдэхүүн, гол худалдан авагч БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүнээс хамаарсан Кобб-Дугласын функцийн хэлбэртэй гэж үзье.

2. МУ-ын үндэсний статистикийн хороо

Нүүрсний экспортын биет хэмжээ /хоёр улсын/

	Нүүрсний экспорт биет хэмжээгээр	Бодит ДНБ, 100 сая юань	ДНБ 2005 оны үнээр, сая төгрөг
1995	1.0	15317.1	550253.7
1996	0.5	16556.5	646559.3
1997	0.2	17871.2	832635.6
1998	3.1	19252.3	817393.4
1999	0.0	20749.0	925345.8
2000	0.6	22860.5	2109411.0
2001	1.9	25092.7	2131059.7
2002	10.9	27758.4	2217285.1
2003	435.4	30960.3	2340718.1
2004	1635.1	35076.4	2591592.8
2005	2217.8	39857.2	2779578.3
2006	2380.1	45926.6	3017425.8
2007	3269.0	53850.5	3639987.7
2008	4169.3	60077.8	3963960.0
2009	7113.2	65675.5	3913673.2
2010	16726.2	74881.0	4162784.9
2011	21296.0	83672.8	4891840.0
2012	20915.5	89561.4	5492723.0

Эх үүсвэр: Монгол Улсын Статистикийн хороо, БНХАУ-ын статистикийн эмхэтгэл

Кобб-Дугласын функцийн ерөнхий хэлбэр:

$$Q = A * X^{\alpha} * Y^{\beta} \quad (1)$$

A - тогтмол

X, Y - хувьсагчүүд

α, β - мэдрэмжүүд

Тооцооллын үр дүн:

$$EX_{coal} = \frac{1}{10^{32}} * GDP_{mon}^{0.66} * GDP_{chn}^{6.67} \quad (2)$$

EX_{coal} - нүүрсний экспортын биет хэмжээ

GDP_{mon} -Монгол улсын ДНБ

GDP_{chn} - БНХАУ-ын бодит ДНБ

Тооцооллын үр дүнгээс харахад монголын нүүрсний экспорт БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүнээс хүчтэй хамааралтай, дотоодын эдийн засгаас сул хамааралтай байна. Хятадын эдийн засгаас хүчтэй хамааралтай байгаа нь бараг цорын ганц экспортын зах зээл нь одоогоор БНХАУ байгаатай холбоотой байж болох юм.

Дүгнэлт

Нүүрсний экспортын судалгааны үр дүнд дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Нүүрсний экспорт нь дэд бүтцийн хөгжлөөсөө шалтгаалан ашиг муутай байна. Байгаль экологид муугаар нөлөөлж байна. Энэ нь зөвхөн монголын талын асуудал биш. Тал хээрээс дэгддэг шар шороон шуурга зэрэг нь аль хэдийн бүс нутгийн хэмжээний аюул болоод байна. Тиймээс монгол улсад уул уурхайн бүтээгдэхүүнийг аль болох гүн боловсруулалт хийх нь хятадын ч монголын ч эрх ашигт харшлахгүй учраас хамтран шийдвэрлэх, зарим нэгэн үйлдвэрийг монгол улсад барьж байгуулахад хамтрах шаардлагатай байна.
- Нүүрсний экспорт Хятадын эдийн засгийн хөгжлөөс хүчтэй хамааралтай байна. Зөвхөн нэг зах зээлээс хараат байх нь монголын эрх ашигт харш юм. Тиймээс дотоодын дэд бүтцийн сүлжээг өргөтгөх замаар Зүүн Өмнөд Азийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах шаардлагатай байна.

Ашигласан ном зүй:

1. Статистикийн эмхэтгэл 1990- 2008
2. Mineral resources and agriculture authority, Mining Sector : Market research of natural resources, Review, 2008
3. North East Asian countries compared usage market research: research report, National University of Mongolia, Center for Asian Studies
4. International trade:Theory&Evidence, James R.Markusen, James R.Mervin, Keith E.Maskus
5. <http://www.mbendi.com/indy/ming/coal/as/kr/p0005.htm>
6. <http://stat.wto.org/CountryProfile>
7. http://mram.gov.mn/index.php?option=com_content&task=blogcategory&id=83&Itemid=136
8. <http://www.CIA.org/worldfactbook>
9. П.Лхамсүрэн: “Монгол Улсын эдийн засгийн бүтцийн шинжилгээ”, “Үндэсний аюулгүй байдал ба Уул уурхайн салбар” эрдэм шинжилгээний хэлэлцүүлсэн илтгэл. 2013 оны 4-р сарын 26, УБ хот
10. П.Лхамсүрэн: “Монгол Улсын эдийн засагт үзүүлэх уул уурхайн салбарын нөлөө, цаашдын төлөв”, : “Уул уурхайн салбар дахь Монгол, Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл, 2013 оны 4-р сарын 18, УБ хот
11. П.Лхамсүрэн: “The future tendency of Mongolian trade with Eastern Asian countries”, “Contemporary of issues in East Asia” ЭШ-ний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. 2010 оны 4-р сарын 23, Сөүл хот